



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 10

Өмнөдэлгэр сум

**Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хороог
байгуулж түүний бүрэлдэхүүн ажиллах
журмыг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Хоёрдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороог байгуулж түүний бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороог байнгын, үр дүнтэй ажиллуулахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд, хороог байнгын, тасралтгүй ажиллах бололцоог хангаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ


Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн
Хоёрдугаар хуралдааны 10 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт



ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- 1.Төрийн байгуулалт, хууль эрхзүй, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо
Г.Алтантуяа, Ж.Энххуяг, Р.Энхтөр, С.Тэгшжаргал, М.Сод-Ирээдүй
- 2.Нийгмийн бодлого, хүний хөгжил, өргөдөл гомдолын асуудал эрхэлсэн хороо
Э.Ган-Эрдэнэ, Б.Давхарбаяр, Ц.Оюун-Эрдэнэ, Б.Оюунгэрэл, А.Баянмөнх
- 3.Төсөв, санхүү, дэд бүтцийн асуудал эрхэлсэн хороо
А.Жаргалсайхан, С.Сувдбаатар, Ц.Пүрэвдорж, Д.Наранчимэг, Г.Энхтунгалаг
- 4.Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн хороо
Р.Цогхүү, В.Лутбэх, Г.Эрдэнэсүвд, Ж.Мөнхжаргал, Х.Будсүрэн
- 5.Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороо
Д.Энхбаатар, Н.Ганбаатар, Л.Ханджав, Н.Мөнхбат, Б.Сэмжид

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
20~~24~~оны ~~12~~ дугаар сарын ~~26~~ ны өдрийн
Хоёрдугаар хуралдааны ~~10~~ дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт



ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРОО ТҮҮНИЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Хурлын үйл ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулах, иргэдийн оролцоог хангах, эргэх холбоотой ажиллах, санал, санаачлагыг Хурлын шийдвэрт тусгах, сум, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхойлох, Төлөөлөгчийн үйл ажиллагааг байнгын ажил хэрэгч, тасралтгүй явуулахад энэхүү журам үйлчилнэ.

1.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороо /цаашид Хороо/ нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлыг иргэд олон нийт, холбогдох байгууллагын оролцоотой судалж боловсруулах, шалгаж танилцах, үнэлэлт дүгнэлт гаргах, Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал боловсруулж хэлэлцүүлэх, гаргасан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах, сахилга хариуцлага тооцуулах зэргээр ажиллана.

1.3.Хороо жилээр ажлаа төлөвлөн Хурлаараа хэлэлцэн батлах бөгөөд биелэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд хагас жилд нэгээс доошгүй удаа, Хуралд жилд нэг удаа танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж байна.

1.4.Хороо шаардлагатай тохиолдолд Хурлын бусад хорооны Төлөөлөгчийн саналыг харгалзан ажилдаа татан оролцуулж болох бөгөөд мэргэжлийн байгууллага, ажилтнууд, иргэдийг мөн ажиллуулж болно.

1.5.Хороодын гишүүд тухайн хороонд 1 жил ажиллаад өөр хороонд ажиллах саналаа хурлын хуралдаанд танилцуулж бусад хороонд шилжин ажиллаж болно.

1.6.Хороо асуудлыг шуурхай, ажил хэрэгч шийдвэрлэх зорилгоор дэд хороо, ажлын хэсэг байгуулж болох бөгөөд саналаа Хурлын даргад хүргүүлж шийдвэрлүүлнэ. Дэд хороо байгуулах асуудлыг Хурлын дарга ирүүлсэн саналын дагуу Хуралдаанд оруулж, шийдвэрлүүлнэ.

Хоёр.Хороо байгуулах

2.1.Хороог үйл ажиллагааны дараах салбар чиглэлээр байгуулна.

- 2.1.1.Төрийн байгуулалт, хууль эрхзүй, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо
- 2.1.2.Нийгмийн бодлого, хүний хөгжил, өргөдөл гомдолын асуудал эрхэлсэн хороо
- 2.1.3.Төсөв, санхүү, дэд бүтцийн асуудал эрхэлсэн хороо
- 2.1.4.Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн хороо
- 2.1.5.Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороо

2.1.1.Төрийн байгуулалт, хууль эрхзүй, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо

Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, батлан хамгаалах бэлэн байдал, цэрэг иргэний хамгаалалт, ард түмний санал асуулга, төр, сүм хийдийн харилцаа, байгууллагын дотоод хяналт хариуцсан нэгж, хэсгүүдийн үйл ажиллагаа, байгууллагуудын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, Хурлын Төлөөлөгчөөс Засаг даргад тавьсан асуулгын хариуг шийдвэрлэсэн байдал, хууль тогтоомж, хурлын шийдвэрийн хэрэгжилт, төлөөлөгчдийн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахдаа баримтлах хэм хэмжээг зохицуулах, нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн байгууллага, ААН, түүнд ажиллаж буй албан хаагчид, иргэдийн сахилга хариуцлагыг сайжруулах, нийгмийн хэв журмыг хангах, Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, сумын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах асуудлыг хариуцна.

Хийх ажлын чиглэл:

Суманд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын явцад хяналт тавих, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх, ИТХ-ын Төлөөлөгчдийн ёс зүйн манлайллыг хангах, зэрэг асуудлыг хариуцна.

Хариуцан ажиллах байгууллагууд:

Сумын ИТХ-ын Төлөөлөгчид, сумын ЗДТГ, Төрийн байгууллагууд, ГХУСАЗСЗ, Хэсгийн төлөөлөгч, цагдаа, ААН

2.1.2.Нийгмийн бодлого, хүний хөгжил, өргөдөл гомдолын асуудал эрхэлсэн хороо

Нийгмийн хүрээнд хөгжлийн өнөөгийн болон хэтийн төлөв хандлагыг тодорхойлон хүүхэд, залуучууд бүх талаар сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалах, ажил хөдөлмөр эрхэлж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж нөхцөл бүрдүүлж, нийгмийн бүлэг бүрд шаардлагатай дэмжлэгийг оновчтой болгох

Хийх ажлын чиглэл:

Боловсрол, соёл урлаг, хүн амын бодлого, хүн, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, гэр бүлийн хөгжил, иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх, ардын өв уламжлал, хүн амын эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн халамж, нийтийн

биеийн тамир спорт, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Хариуцан ажиллах байгууллагууд:

Нийгмийн бодлогын түшмэл, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Нийгмийн даатгал, Халамж, Номын сан, Хүүхдийн зөвлөл, Хүүхэд хамгааллын хамтарсан баг, Ахмадын хороо, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Залуучуудын холбоо, Төрийн бус байгууллагууд

2.1.3 Төсөв, санхүү, дэд бүтцийн асуудал эрхэлсэн хороо

Нутаг дэвсгэрийн эдийн засаг, санхүүгийн хэтийн төлөвийг шинжлэн дүгнэж, дэд бүтцийн хөгжлийн хандлагыг тодорхойлох бодлого боловсруулж хэрэгжүүлэх асуудал хариуцна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалт, ажил үйлчилгээний явц, гүйцэтгэл

Хийх ажлын чиглэл:

Сумын төсөв, төсвийн орлого, зарлагын хяналт, санхүү, зээл, албан татвар, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, орон нутгийн өмчийн асуудал, орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд зарлагдаж буй тендер, худалдан авалт, санхүүжилт, түүний гүйцэтгэл, аялал жуулчлал, эрчим хүч, дулаан, зам тээвэр, харилцаа холбоо, сумын тохижилт соёлжилтын асуудлууд

Хариуцан ажиллах байгууллагууд:

Сумын Засаг даргын орлогч, Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч, Татвар, Банк, Эрчим хүч, Дулаан.

2.1.4 Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн хороо

Нутаг дэвсгэрийн мал аж ахуй, газар тариалангийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох, малжуулах, тахиа, гахай, зөгий зэрэг туслах аж ахуй хөгжүүлэх, фермер, жижиг үйлдвэрлэл, нөхөрлөл, хоршоолол, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, сумын хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад хяналт тавих зэрэг асуудлыг хариуцна.

Хийх ажлын чиглэл:

Газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдал, хангамж, мал аж ахуйн бодлого, мал мах, ХАА-н бүтээгдэхүүний хяналт, малын өвчин, малын даатгал, малын үржил селекц, эрчимжсэн мал өсгөх бодлогыг дэмжих

Хариуцан ажиллах байгууллагууд:

Сумын Засаг даргын орлогч, ХАА-н тасаг, МЭҮТасаг, Мал эмнэлгүүд, Газар тариалан эрхэлж буй байгууллагууд, иргэд, Малчдын бүлэг хоршоо, малчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид

2.1.5 Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороо

Сумын байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчны талаар хууль тогтоомжийг хэрэгжилт, Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Хийх ажлын чиглэл:

Газар, түүний хэвлий, ой, ус, амьтан болон бусад баялаг, ашигт малтмал олборлолт, Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар, байгаль орчны төрийн хяналт, усны нөөц, бохирдолт, хог хаягдал, ан агнуур, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй амралтын газар, гэр буудал, зочлох үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэд

Хариуцан ажиллах байгууллагууд:

Сумын БОХУ-ын байцаагч, байгаль хамгаалагч, Хэнтий шинэс сум дундын ойн анги, Орчны бүсийн зөвлөл, ХХТХГ-ын захиргаа, Хурх Хүйтний хөндийн байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаа, Дэлхийн өв, Бурхан халдун уул түүнийг хамгаалсан тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа, ДБХСан, Байгаль хамгаалах нөхөрлөлүүд, ОМБайгууллагууд, Цаг уур.

Гурав.Хорооны үйл ажиллагааны баталгаа

3.1.Хороо ажиллах төсвийг "Төсвийн тухай" хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1 заалтын хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт багтаан жил бүр төлөвлөж, санхүүжүүлнэ. Хороодын ажлыг дүгнэж олгох шагналын төсвийг багтаан тусгана.

3.2.Ажлын удирдамжийг Хурлын даргын захирамжаар батлах бөгөөд тухайн ажлын хэсэгт орж ажиллах бүрэлдэхүүний үндсэн ажил үүргийг нь зохицуулах, чөлөө олгох үүргийг Төлөөлөгчийн үндсэн байгууллагын удирдлага хүлээнэ.

3.3.Хороо нь үйл ажиллагаагаа зохион байгуулах болон Хурлын даргын захирамжаар батлагдсан удирдамж бүхий ажлын хэсэгт сумын нутаг дэвсгэрт байгаа төр, хувийн хэвшлийн бүх байгууллага хуулийн хүрээнд дэмжих, иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал дүгнэлт, хуулиар тогтоосон хэм хэмжээ, гаргасан шийдвэрийнх нь хүрээнд үйл ажиллагаагаа хянуулах, холбогдох баримт бичиг, ажлын тайлан, шийдвэр хэрэгжүүлсэн тухай илтгэх хуудас зэргийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

3.4.Иргэд, байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагын үйл ажиллагаа, байгууллагын удирдах албан тушаалтны гаргасан шийдвэр, орон нутгийн удирдах албан тушаалтны үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэл, гаргасан шийдвэр, аймаг орон нутагт хэрэгжиж байгаа дотоод гадаадын төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой өөрийн салбар, үйл ажиллагаанд хамаарах өргөдөл гомдлыг Хурлын бүх хороо хэлэлцэн шийдвэрлэж болно.

Дөрөв.Хорооны ажлыг дүгнэх журам

4.1.Тайлант жилд хурлын хороодын сурталчилгаа, хяналт шалгалтын ажил, хорооны бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилласан байдал, хуралдаанаар хэлэлцэх асуудлын хүрээнд байгууллага, албан тушаалтны илтгэл сонсголыг хэлэлцэн дүгнэлт гаргаж Хуралдаанд уламжилсан байдал, иргэдийн санал хүсэлт болон бусад асуудлуудыг шийдвэрлүүлж ажилласан байдал, хийсэн ажлын гүйцэтгэл, хугацаандаа бичиж өгсөн тайлан зэргийг харгалзан жилийн эцэст 2 хүртэл хороог шалгаруулна.

4.2.Шалгуур үзүүлэлтийн дагуу Хурлын хорооны ажлыг дүгнэнэ.

4.3.Шалгуур үзүүлэлт:

- 4.3.1.Хорооны үйл ажиллагаа тогтмолжсон байх
- 4.3.2.Хороо сар бүр хуралдсан байх
- 4.3.3.Хороо жилд хийх ажлаа оновчтой төлөвлөж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хийж хэрэгжүүлсэн байх.
- 4.3.4.Төлөвлөгөөний хэрэгжилтийг Хорооны хурлаар хэлэлцэн үр дүнгээ тооцсон байх
- 4.3.5.Хяналт шалгалтаар гарсан зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх, үр дүнг эргэж тооцсон байх
- 4.3.6.Жилд 2-оос доошгүй удаа багт ажилласан байх

Тав.Хороодын жилд хийсэн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

5.1.Тоо хэмжээ, хугацаа

Жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлаа дүгнүүлнэ.

5.2.Чанар

- 5.2.1.Хороодын жилд хийх ажлын төлөвлөгөө /Төлөвлөгөөний төсөл/
- 5.2.2.Хорооны хурал хийсэн тоо, хэлэлцсэн асуудал /Хурлын тэмдэглэл/
- 5.2.3.Мэдээлэл, сургалт сурталчилгаа /Олон нийтэд нийтийг хамарсан ажил, мэдлэг олгох сургалт мэдээлэл хийсэн удирдамж, товч тайлан/
- 5.2.4.Хяналт шалгалт хийсэн тоо /Байгууллага, ААН-д хяналт хийсэн удирдамж, хийсэн ажлын товч тайлан/
- 5.2.5.Зөвлөмж хүргүүлж сумын ИТХ-ын Зөвлөлд танилцуулах /Байгууллагуудад ажилласан ажлын талаар гарсан дутагдал зөрчлийг арилгуулах зөвлөмж, албан тоот/
- 5.2.6.Зөвлөмжийн хэрэгжилтийг эргэж тооцсон эсэх /Байгууллагад өгсөн зөвлөмжийн дагуу эргэж танилцсан байдал, товч тайлан/
- 5.2.7.Жилд хийсэн шинэлэг ажил, санаачилга
- 5.2.8.Бүх нийтийг хамарсан томоохон үйл ажиллагаа
- 5.2.9.Баримт бичгийн бүрдүүлэлт

Зургаа.Тайлан үнэлэх

6.1.Хороодын хийсэн ажлыг шалгуур үзүүлэлтэд заасан удирдамж, хүснэгтийн дагуу үнэлэх бөгөөд шинэлэг үйл ажиллагаа зохион байгуулсан байдал, бүх нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулсан тохиолдолд давуу тал болно.

6.2.Хороод жилийн хийх ажлын төлөвлөгөө, баталсан удирдамж, гүйцэтгэлийн тайлан, зөвлөмж, албан тоот зэрэг жилийн хийсэн ажлын баримтыг сумын ИТХ-ын ажлын албанд өгч архивын баримт болгоно.

Долоо.Шалгаруулалт

7.1.Хурлын Хороодын хийсэн ажлын тайлан, гүйцэтгэлийг жилийн эцэст 12 дугаар сарын 15-ны дотор хүлээн авна.

7.2.Сумын ИТХ-ын Зөвлөл, Хурлын хороодын өргөтгөсөн хуралдаанаар ирүүлсэн тайланг хэлэлцүүлэн шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.

7.3.Тайлан дүгнэхэд ажлын үзүүлэлтээр эхний 1, 2 дугаар байранд орсон Хороодыг жилийн эцэст мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.